



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” СЭДЭВТ НИЙЦЛИЙН АУДИТ

2025 оны 5 дугаар сар

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитад төсвийн төвлөрүүлэн захирагч, орон нутгийн тусгай сан, нөхөрлөл, боловсролын хувийн байгууллага болон төрийн нууцад хамаарах байгууллагаас бусад 174 төсвийн захирагчдаас 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд эх олонлогийг төлөөлөхүйц 52 байгууллагын 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны баримт материалыг хамруулав.

Төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавих зорилгоор **ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ**-ийг 2022 онд баталсан. (6 удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.)

АУДИТЫН ГОЛ ҮР ДҮН (НӨХЦӨЛ БАЙДАЛД СУУРИЛСАН ДҮГНЭЛТ):

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА (ТӨСӨВ БАТЛАХ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА), ТӨСВИЙН БҮХ ШАТНЫ ЗАХИРАГЧ, САНХҮҮГИЙН АЖИЛТНУУД ДЭЭРХ ХУУЛИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ХАНГАЛТГҮЙ, ТОГТВОР СУУРЬШИЛГҮЙ АЖИЛЛАХ БОЛОН ХАРИУЦЛАГАГҮЙ БАЙДЛААС УЛБААЛАН ХАРИЛЦАН АДИЛГҮЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

1. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААГДСАН БУСАД АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Дорноговь аймгийн Засаг даргын орлогчоор 2 орон тоо батлагдан ажиллаж байснаас 2022 оны 5/10 дугаар захирамжаар 1 орлогч даргыг чөлөөлсөн байна. Үүний үр дүнд жил бүр 19.8 сая төгрөгийн цалин, урамшуулал болон 3.3 сая төгрөгийн шатахууны зардлыг тус тус хэмнэж ажиллахаар байна. Мөн түүвэрт хамрагдсан 52 байгууллага нь зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулаагүй байна.

Орон нутгийн хэмжээнд аймаг, сумын Засаг дарга, ИТХ-ын даргаас бусад албан тушаалтанд автомашин ашиглахгүй байхаар заасан байна. Гэвч түүвэрт хамрагдсан 52 байгууллагаас аймгийн Засаг даргын орлогч, Тамгын дарга нар албан хэрэгцээнд авто тээврийн хэрэгсэл ашиглаж, жилд дунджаар 5.5 сая төгрөгийн шатахуун зарцуулж байгаа нь орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашиныг татан төвлөрүүлэх, хүлээлгэн өгөх арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллаагүйгээс шалтгаалж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн 709 автотээврийн хэрэгслээс 431 (2023 онд-171 ширхэг, 2024 онд-238 ширхэг, 2025 онд-22 ширхэг) улсын дугаарын дэвсгэр өнгийг сольж, цахимаар бүртгэсэн байна. Харин 64 байгууллагын 278 авто тээврийн хэрэгсэл ялгагдах тод дэвсгэр бүхий улсын дугаарыг аваагүй байна.

Түүвэрт хамрагдсан 52 байгууллагаас 4 байгууллага нь хуулиар тогтоосон дүрэмт хувцастай бөгөөд бусад байгууллагаас тус хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт

7.9 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэн. Хавсралтаас дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.

Түүвэрт хамрагдсан 6 ТБОНӨХЭ-ийн захирал болон бусад албан хаагчдын цалин хөлсийг тогтоосон байдалд дүн шинжилгээ хийхэд нийтлэг цалин хөлсний жишгийг Засгийн газар, аймгийн болон Замын-Үүд сумын ИТХ-аас тогтоогоогүйгээс захирал, дарга нарын үндсэн цалин 1.5-4.9 сая төгрөгийн хооронд **харилцан адилгүй** байна.

Аймаг болон Замын-Үүд сумын 2024 оны батлагдсан төсөвт нийт 20 албан хаагчид 380.9 сая төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж төлөвлөснөөс **5 албан хаагч** өөрийн хүсэлтээр тэтгэвэр гаргах хугацаагаа хойшлуулснаас шалтгаалжээ. Мөн төлөвлөгөөнд тусгагдаагүй **1 албан хаагчид 3.6 сая** төгрөгийн тэтгэмжийг олгосон бөгөөд **үүссэн давхардал байхгүй** болно.

Түүвэрт хамрагдсан байгууллагаас **аймгийн Татварын газар** нь хууль тогтоомжид заагдаагүй 69.7 сая төгрөгийн нэмэгдэл цалингийн урамшууллыг олгосон зөрчил гаргасан байна.

Дорноговь аймгийн 11 сумын 100 жилийн ойн баярын арга хэмжээ 2024 онд тохиосонтой холбогдуулан контент, нэвтрүүлэг, кино бэлтгэхээс гадна салбарын үйл ажиллагааг сурталчлах контентод 3 байгууллага нийт **30.7 сая** төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн байна. Мөн 2 байгууллага төсвийн болон байгууллагын хөрөнгөөр нийт 2.2 сая төгрөгийн согтууруулах ундаа (оргилуун дарс) худалдан авсан байна.

ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасны дагуу түүвэрлэгдсэн 52 байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2024 онд 354.9 сая төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд орон нутгийн хэмжээнд төсвийн байгууллага, ТБОНӨХЭ-ийн дулааны зардлыг талбайн хэмжээгээр тооцдог байна. Мөн бичиг хэргийн зардлыг 28.2 сая төгрөгөөр, шуудан, холбоо, интернетийн зардлыг 26.6 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь **төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-ийг** ашиглаж эхэлсэнтэй холбоотой байна.

2. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

Түүвэрт хамрагдсан 52 байгууллагуудаас Гаалийн ерөнхий газрын харьяа Сайншанд дахь гаалийн газар нь “Албан конторын сангийн ажил гүйцэтгэх” ХАА-аас хэмнэгдсэн 10.9 сая төгрөгийг байгууллагын урсгал засварт зарцуулсан зөрчил илэрсэн нь ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т *“хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх”* гэж заасантай нийцэхгүй байна.

ОНТХО-аар 2024 онд шинээр хэрэгжих нийт 58,743.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 109 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан. Тус жагсаалтыг 2025 оны 7 дугаар сарын өөрчлөлтөөр **5 ТАХ-ний** 2024 онд санхүүжүүлэх дүнг **2,908.1** сая төгрөгөөр бууруулж, шинээр **2,908.1** сая төгрөгийн **8 ТАХ-г** хэрэгжүүлэхээр баталсан байна. Мөн 9 дүгээр сард нэмэлт өөрчлөлтөөр аймгийн төсвийн орлогыг 9,812.1 сая төгрөгөөр, зарлагыг нийт 7,470.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь хөрөнгө оруулалтын ТАХ-г батлах **эрэмбийг баримталж ажиллахгүй** байна.

Аймгийн ИТХ-аар хөрөнгө оруулалтын зардлыг 7 дугаар сард 8 ТАХ, 9 дүгээр сард 2 ТАХ, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтын зардлыг 9 дүгээр сарын өөрчлөлтөөр 16 ТАХ нэмэлтээр баталсан нь ТАХ-ний тендер зарлах болон гэрээ байгуулах хугацаа оройтож, төсвийн жилд бүрэн гүйцэтгэх боломжгүй болон дараагийн төсвийн жилд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байгаа нь төсвийн төлөвлөлтийг **хууль журмын дагуу гүйцэтгээгүйгээс** шалтгаалж байна.

Дорноговь аймагт улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх **19 ТАХ-ны** төсөвт өртгийг 2024 онд **нэмэгдүүлээгүй** байна.

ОНТХО-ын ТАХ-ны жагсаалтад **улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй** 1,851.4 сая төгрөгийн 10 ТАХ-г төлөвлөгөөнд тусгасан зөрчил илэрлээ.

- ▶ **ЦАХИМ ДЭЛГҮҮР-т** 2165 ерөнхий гэрээний дагуу 998 нэр төрлийн бараа, үйлчилгээг 550 нийлүүлэгч байгууллагаас байршуулсан байна. Түүвэрт хамрагдсан 52 байгууллагаас 9 байгууллага нь 2024 онд цахим дэлгүүрээс 575 нэр төрлийн **913.4 сая** төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан байна.
- ▶ Харин **33** байгууллага нь нийт **6,324.9 сая** төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй **зөрчил** илэрсэн. Энэ нь захиалагч байгууллагуудын цахим дэлгүүрийн талаарх ойлголт дутмаг, холбогдох мэргэжлийн байгууллагаас арга зүйн зөвлөгөө, мэдээллийг түгээх ажил зохион байгуулаагүйтэй холбоотой байна.

3. **ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БУСАД ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГААС ХОЛБОГДОХ ҮҮРЭГ ЧИГЛЭЛИЙГ ӨГСӨН БОЛОВЧ ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд тус хуулийн хэрэгжилттэй холбоотой чиглэсэн хяналт шалгалтыг **Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хийгээгүй** байна. Монгол Улсын Сангийн сайдаас “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж батлагдаагүй тул хуульд заасан хяналт шалгалтын үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй гэсэн тайлбарыг өгсөн.

Төрийн аудитын байгууллагаас МҮЕА-ын 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын дагуу санхүүгийн тайлангийн аудитаар 2023 онд 634.7 сая төгрөгийн, 2024 онд 406.6 сая төгрөгийн зөрчил тус тус илрүүлж, 1.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 260.0 сая төгрөгийн албан шаардлага, 144.7 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлэн, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газраас дараах шийдвэрлэлтийг хүргүүлсэн байна.

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн ТЕЗ байгууллага	10	229.5	1	0.5	7	219.8	2	9.2
2	Бусад байгууллага	12	177.1	2	1.3	2	40.3	8	135.5
НИЙТ		22	406.6	3	1.8	9	260.1	10	144.7

Хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч зөрчил **давтан гарсаар** байгаа нь төсөв захиран зарцуулах эрх бүхий албан хаагчдын хариуцлагагүй (шийдвэрлэлтийг хэрэгжүүлэн ажилладаггүй) болон ажлын байрны тогтворгүй байдал, хууль, журмын мэдлэг хангалтгүй, дотоод болон мэргэжлийн байгууллагын хяналт сул зэргээс шалтгаалж байна.

“ТХТХ-ийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоолд **6 арга хэмжээг**, “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолд **9 арга хэмжээг** баталж, холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасан байна. Энэхүү тогтоолоор аймгийн ТЕЗ болон ТБОНӨХЭ-үүдийн гүйцэтгэх захиралд үүрэг болгосон хэрэгжилтийг дүгнэх боломжтой нийт 7 арга хэмжээнээс 3 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд **42.8 хувьтай** хэрэгжсэн байна.

Түүвэрлэгдсэн 52 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хуулийн **8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 15.1.7 дахь заалтуудтай** холбоотой зөрчил 68.4 хувийг эзэлж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилт харилцан адилгүй, төсвийн зарлагын хэмнэлт нь **зөвхөн ТХТХ-ийг хэрэгжүүлснээр үүссэн хэмнэлт эсэхийг тодорхойлох боломжгүй** байна.

УАГ-Т САНАЛ БОЛГОСОН АСУУДЛУУД:

1. МУЗГ-ын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дугаар тогтоолын 1-5 дугаар арга хэмжээний холбогдох журам, **хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхой бус** байгаагаас орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байх тул **эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох.**
2. Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг хуульд заасны дагуу **шинэчлэн батлах**

ЗӨВЛӨМЖ БОЛГОСОН АСУУДЛУУД

АЙМГИЙН БОЛОН ЗАМЫН-ҮҮД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА НАРТ:

Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшинг харгалзан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчдын цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоох

АЙМГИЙН АВТОТЭЭВРИЙН ТӨВ БОЛОН АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАМЫН-ҮҮД САЛБАРЫН ДАРГА НАРТ:

Тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд хуулийг хэрэгжүүлэн ажиллахтай холбоотой чиглэлийг хүргүүлж, арга хэмжээ авч ажиллах

ӨРГӨН СУМЫН СОЁЛ, СПОРТ ТӨВ, ХАТАНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ БОЛОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА НАРТ:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1-т “цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлж, төсвийн болон байгууллагын хөрөнгөөр албан хаагчдад дүрэмт хувцас худалдан авахгүй байх

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА НАРТ:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4-т “... аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж, цаашид салбарын, байгууллагын үйл ажиллагаа болон бусад мэдээлэлтэй холбоотой нэвтрүүлэг, контентыг санхүүжүүлэхгүй байх

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА САЙНШАНД ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГАД:

ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж, цаашид хэмнэлтийг зарцуулахгүй байх

АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА Ц.САРУУЛЦОГТ ТАНАА:

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.8.4-т заасан “цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах” чиг үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, төсвийн байгууллага болон ТБОНӨХЭ-үүдийн удирдлага, санхүүгийн ажилтанд сургалт зохион байгуулах

“ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” СЭДЭВТ НИЙЦЛИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Шалгагдагч байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Зөрчигдөж байгаа хууль, тогтоомж, бодлогын баримт бичгийн заалт
1	Дорноговь аймгийн Автотээврийн төв	Төрийн болон орон нутгийн өмчийн 10 байгууллагын 13 автотээврийн хэрэгсэл ялгагдах тод дэвсгэр бүхий улсын дугаар хэрэглээгүй байна.	-	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг
2	АТҮТ-ийн Замын-Үүд дэх салбар	Төрийн болон орон нутгийн өмчийн 10 байгууллагын 13 автотээврийн хэрэгсэл ялгагдах тод дэвсгэр бүхий улсын дугаар хэрэглээгүй байна.	-	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг
3	Өргөн сумын Соёл, спортын төв	Өргөн сумын Соёл, спортын төвийн албан хаагчдад 1,640,000 төгрөгийн 12 ширхэг монгол цамц, хүрэм худалдан авсан байна.	1.6	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт
4	Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төв	Тайлант онд нормын хувцас, зөөлөн эдлэл зардлаас 22 ширхэг хатгамалтай бомбер худалдан авахад 2,783,000 төгрөгийг зарцуулсан байна.	2.8	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг
5	Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар	Аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны А/59 дүгээр тушаалаар Зүүн болон говийн бүсийн аймгуудын ЗДТГ-ын албан хаагчдын нэгдсэн спортын арга хэмжээний 50 ширхэг тэмцээний хувцас худалдан авахад нийт 3,600,000 төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан байна.	3.6	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг
6	Аймгийн ИТХ	Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшинг харгалзан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчдын цалин хөлсний нийтлэг жишгийг батлаагүй байна.	-	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт
7	Замын-Үүд сумын ИТХ	Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшинг харгалзан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчдын цалин хөлсний нийтлэг жишгийг батлаагүй байна.	-	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт
8	Сайншанд сумын ЕБ-ын 3 дугаар сургууль	Сургуулийн захирлын 2024 оны А/74 дүгээр тушаалаар байгууллагын ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга, гишүүдэд нийт 594,000 төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон байна.	0.6	Албан шаардлага	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг

9	Гаалийн ерөнхий газрын харьяа Сайншанд дахь гаалийн газар	Гаалийн ерөнхий газрын харьяа Сайншанд дахь гаалийн газар нь “Албан конторын сангийн ажил гүйцэтгэх” ХАА-аас хэмнэгдсэн 10,900,000 төгрөгийг байгууллагын урсгал засварт зарцуулсан байна.	10.9	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт
10	Худалдан авах ажиллагааны газар	1. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.8.4-т заасан “цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах” чиг үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, төсвийн байгууллага болон ТБОНӨХЭ-үүдийн удирдлага, санхүүгийн ажилтанд сургалт зохион байгуулаагүй байна	-	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйл
11	Дорноговь аймгийн Засаг дарга	Аймгийн Засаг даргын 2024 оны А/126 дугаар захирамжаар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчлэл, үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх 4 төрлийн контент хийлгэхэд 19,700,000 төгрөгийг нөөц сангаас зарцуулсан байна.	19.7	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт
12	Дэлгэрэх сумын ЗДТГ	Сумын 100 жилийн ойн баримтат киноны үлдэгдэл төлбөр болох 1,000,000 төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн байна	1.0	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт
13	Замын-Үүд сумын ЗДТГ	Сумын 30 жилийн ойн арга хэмжээн хүрээнд 10,000,000 төгрөгөөр баримтат контент гэрээний дагуу гүйцэтгүүлсэн байна	10.0	Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт
14	Дорноговь аймгийн Татварын газар	Аймгийн Татварын газрын даргын 2024 оны А/33 дугаар тушаалаар 41 албан хаагчид цалингийн зардлаас нийт 69,785,448 төгрөгийн нэмэгдэл цалингийн урамшууллыг олгосон байна	69.7	Албан шаардлага	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт
15	Сайншанд сумын ЗДТГ	Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс харшийн шинэ жилд зориулж 20 ширхэг оргилуун дарсыг 198,000 төгрөгөөр худалдан авсан байна. Оргилуун дарс= согтууруулах ундаа alc.vol 11%	0.2	Төлбөрийн акт	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7 дахь заалт
16	Дорноговь АЗЗА ТӨХК	Захирлын 2024 оны А/47 дугаар тушаалаар байгууллагын шинэ жилийн баярын үйл ажиллагаанд зориулан, 40 ширхэг оргилуун дарс худалдан авахад 2,000,000 төгрөгийг зарцуулсан байна. Оргилуун дарс= согтууруулах ундаа alc.vol 11	2.0	Төлбөрийн акт	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7 дэх заалт
НИЙТ МӨНГӨН ДҮН			122.2		